



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх санхүүгийн аудит

Аудитын код: ЗАА-2022/01/СТА-ТЕЗ



Улиастай
2021 он

Дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа
Утас: 70463612 Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn
Аудитын менежер Б.Дагвасүрэн
Утас: 70463783 Цахим хаяг: dagvasurenb@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Жалбаа
Утас: 89330330 Цахим хаяг: jalbaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. www.audit.mn

Агуулга

Аудитын тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар	2
Завхан аймаг дахь Төрийн аудитын газар	Хүснэгт, графикийн товъёог.....	3
Дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
Аудитын менежер Б.Дагвасүрэн	ЗОРИЛТ -1 Орон нутгийн орлогын төлөвлөлт гүйцэтгэл	
Ахлах аудитор Б.Жалбаа	ЗОРИЛТ 2. Орон нутгийн зарлагын төлөвлөлт, гүйцэтгэл	
	ЗОРИЛТ 3. Нэмэлт санхүүжилтийн орлого, зардал	
	ЗОРИЛТ 4. Авлага, өглөг.....	
2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр	Дүгнэлт	
	Зөвлөмж	
Уг тайланг ТАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал.....	
http://audit.mn	Аудитын тайланг баталгаажуулсан тушаал	

1. ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СЯ	Сангийн яам
СЯХ	Сангийн яам хянасан
СИТХ	Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч

2. ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ТОВЬЁОГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт №1	Суурь орлогын төлөвлөлт, гүйцэтгэл	6
Хүснэгт №2	Татварын орлогын гүйцэтгэл	7
Хүснэгт №3	Төсвийн санхүүжилтийн эх үүсвэр /сангийн чам баталсан/	8
Хүснэгт №4	Төсвийн санхүүжилтийн эх үүсвэр /АИТХ баталсан/	9
Хүснэгт №5	Төсөв хоорондын шилжүүлгийн гүйцэтгэл	11
Хүснэгт №6	Аймгийн суурь зарлагын төлөвлөлт	12
Хүснэгт №7	Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлагын төлөвлөлт	13
Хүснэгт №8	Нийт зардлын гүйцэтгэл	15
Хүснэгт №9	Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага	15
Хүснэгт №10	Нэмэлт санхүүжилтийн орлого	16
Хүснэгт №11	Авлагын үлдэгдэл	18
Хүснэгт №12	Өр төлбөрийн үлдэгдэл	20
Хүснэгт №13	Төсөвт байгууллагын өр төлбөр	
Графикийн товъёог		
№	Тайлбар	Хуудасны дугаар
График №1	Суурь орлогын төлөвлөлт, гүйцэтгэл	7
График №2	Төсвийн орлогын эх үүсвэр	8

3. Аудит хийх бүрэн эрх, үндэслэл

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, дугаар зүйлийн 8.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Завхан аймгийн Төрийн аудитын газар хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

“Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэл, үр дүн”-д аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Хамарсан хүрээ

Орон нутгийн төсөв болон улсын төсвөөс санхүүжилт авсан, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуй нэгж, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл, бусад баримт материалд тулгуурлан аудитыг хийлээ.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Аудитын Дээд Байгууллагуудын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын журам, арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа хөтөлбөр горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана.

- Төрийн Аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Татварын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- ТБОНӨХБАҮХАТухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Холбогдох бусад хууль, журам эрхийн акт

Аудит хийсэн хугацаа:

Аудитыг 2022 оны 04 дүгээр сарын 05-аас эхэлж 04 дүгээр сарын 20-нд дуусгав.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Дагвасүрэн хэрэгжүүлж ахлах аудитор Б.Жалбаа гүйцэтгэв.

ЗОРИЛТ- 1. ОРОН НУТГИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ

Төсвийн суурь орлогын талаар:

Аймгийн төсвийн суурь орлогын Сангийн яамны анх хянасан дүнг өмнөх оны төлөвлөгөөтэй харьцуулахад 1,397.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 1,828.5 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Хувь хүний орлогын буцаан олголт 2021 онд 900.0 сая төгрөг олгохоор төлөвлөж татварын суурь орлогоос хасаж хянасан байна.

Суурь орлогын төлөвлөлт, гүйцэтгэл

Хүснэгт-1 /сая.төг/

Суурь орлого	2020 он			2021 он		
	Анх хянасан	Тодотгосон	Гүйцэтгэл	Анх хянасан	Тодотгосон	Гүйцэтгэл
Татварын орлого	7,631.0	7,455.0	10,346.7	8,842.0	8,842.0	11,927.6
Татварын бус орлого	493.6	523.6	857.4	533.6	533.6	1,963.0
ДҮН	8,124.6	7,978.6	11,204.1	9,375.6	9,375.6	13,890.6



Аймгийн ИТХ-ын хуралдааны 2020 оны 11 дүгээр тогтоолоор Сангийн яамны хянасан суурь орлогыг 982.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан нь Төрийн аудитын газраас 2021 онд 8 нэр төрлийн татварт орлого нэмэгдүүлэх санал оруулж аймгийн ИТХ-ын 2020 оны 78 дугаар тогтоолоор баталсантай холбоотой байна.

Орон нутгийн татварын орлого 2021 онд 13,890.6 /татварын буцаан олголт 768.4 сая төгрөгийг хассан/ сая төгрөг төвлөрсөн нь сангийн яамны батлагдсан төсвөөс 4,515.0 сая төгрөгөөр буюу 48.2 хувиар, аймгийн ИТХ-ын нэмэлт даалгавар 982.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн дүнтэй харьцуулахад 3,533.0 сая төгрөг буюу 34.1 хувиар давж биелсэн байна.

Татварын орлогын гүйцэтгэлийг харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-2 /сая.төг/

д/д	Татварын нэр төрөл	Төлөвлөгөө /СЯХ/	Нэмэлт даалгавар /АИТХ/	Нийт төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлтийн хувь
1	Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах	6,100.0		6,100.0	7,448.3	122.1

Завхан аймгийн ТЕЗ-н төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	хөдөлмөр эрхлэлтийн орлогын					
2	Үйл ажиллагааны орлого	240.0	20.0	260.0	447.6	172.2
3	Хөрөнгийн орлого /хадгаламжийн хүүгийн орлого/	1,000.0	55.0	1,055.0	1,170.6	111.0
4	Шууд бус орлого /хувь хүнээс суутгасан суутгалын орлого/	420.0		420.0	113.5	27.0
5	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	370.0		370.0	385.1	104.1
6	Бууны албан татвар	55.0	12.0	67.0	63.0	94.0
7	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	350.0		350.0	383.4	109.5
8	Улсын тэмдэгтийн хураамж	250.0		250.0	195.9	78.4
9	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	20.0		20.0	13.4	67.0
10	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	110.0	60.0	170.0	127.8	75.2
11	Газрын төлбөр	330.0	15.0	345.0	573.4	166.2
12	Ойн нөөц ашигласны төлбөр	200.0	70.0	270.0	382.1	141.5
13	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.0		0.0	1,350.8	0.0
14	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	290.0		290.0	134.6	46.4
15	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	7.0		7.0	10.7	152.9
17	Малын тоо толгойн татвар		700.0	700.0	542.6	77.5
18	Зам ашигласны төлбөр			0.0		0.0
19	Газрын эрх борлуулсан			0.0		0.0
20	Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсан		50.0	50.0	412.7	825.4
	Татварын орлогын дүн	9,742.0	982.0	10,724.0	13,755.5	128.3
21	Торгуулийн орлого /татварын бус орлого/	500.0		500.0	903.5	180.7
22	Бусад орлого	20.0		20.0		0.0
23	Төсөвт байгууллагын өөрийн орлого	13.6		13.6		0.0
	Татварын бус орлогын дүн	533.6	0.0	533.6	903.5	169.3
	Нийт татварын орлого	10,275.6	982.0	11,257.6	14,659.0	130.2
	Буцаан олголт	900.0		900.0	768.4	85.4
	Цэвэр дүн	9,375.6	982.0	10,357.6	13,890.6	134.1

- ✓ Аймгийн ИТХ-аас нэмэлт даалгавраар өгсөн 8 нэр төрлийн татвараас бууны албан татвар, хог хаягдлын үйлчилгээний хураамж, малын тоо толгойн албан татвар зэрэг 3 нэр төрлийн татвар биелээгүй байна. Харин Сангийн яамны баталсан төлөвлөгөөтэй харьцуулахад нэмэлт даалгавраар өгсөн татваруудаас малын тоо толгойн албан татвараас бусад нэр төрөлд биелсэн байна. Малын тоо толгойн татвар тасарсан нь сумдын ИТХ-аас ковид-19 цар тахлын нөхцөл

Завхан аймгийн ТЭЗ-н төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит
байдалтай уялдуулан малчин иргэдийг татвараас хөнгөлөх шийдвэр гаргасантай
холбоотой байна.

- ✓ Татварын орлогын биелэлтийг сангийн яамны хянасан дүнтэй харьцуулан үзэхэд 4 нэр төрлийн татвар тасарч, бусад нэр төрөлд давж биелсэн байна.

Татварын орлого давж биелэхэд дараах нэр төрлийн татварууд нөлөөлсөн байна. Үүнд:

- I. Үйл ажиллагааны орлогын албан татвар 72.2 хувиар давсан нь малчдад төрөөс арьс шир, ноос, ноолуурын урамшуулал олгосонтой,
- II. Газрын төлбөр 66.2 хувиар давсан нь өмнөх оны төлбөрийн үлдэгдлийн барагдуулалттай холбоотой бол
- III. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийг тайланд онд төлөвлөөгүй бөгөөд гүйцэтгэлээр 1,350.8 сая төгрөг төвлөрсөн нь татварын орлогын биелэлтэд нөлөөлжээ.

Тасарсан орлогууд нь дараах шалтгаантай байна.

1. Шууд бус орлого буюу хувь хүнээс суутгасан суутгалын орлого биелээгүй нь төсөв байгууллагууд иргэдээс худалдан авалт хийхдээ И-баримт авч цахим системд бүртгэж байгаатай холбоотой иргэд хувь хүний орлогоо өөрсдөө тайлагнадаг болсонтой холбоотой байна.
2. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр тасарсан нь төлөвлөсөн хөрөнгө оруулалтын ажил хийгдээгүй, хувийн барилга байгууламж баригдаагүй зэрэгтэй холбоотой байна.
3. Ус рашааны нөөц ашигласны төлбөр тасарсан нь рашаан сувиллын газруудын үйл ажиллагаа хэвийн явагдаагүйтэй холбоотой байна.
4. Улсын тэмдэгтийн хураамж төлөвлөсөн хэмжээнд төвлөрөөгүй байна.

ТЭЗ-ийн төсвийн орлогын талаар:

Сангийн яам Аймгийн ТЭЗ-ийн 2021 онд бүрдүүлэх орлогыг 77,534.8 сая төгрөгөөр анх баталсан бөгөөд төсөвт тодотгол хийж төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,136.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 79,671.7 сая төгрөгөөр баталжээ.


2021 оны батлагдсан төсвийг өмнөх онтой харьцуулахад 1,894.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Төсвийн орлогын эх үүсвэр

д/д	Орлогын нэр төрөл	Хүснэгт-3 /сая.төг/					
		2020 он			2021 он		
		Анх баталсан	Тодотгосон	Зөрүү	Анх баталсан	Тодотгосон	Зөрүү
1	Татварын орлого	7,631.0	7,455.0	176.0	8,842.0	8,842.0	0.0
2	Татварын бус орлого	493.6	523.6	-30.0	533.6	533.6	0.0
3	Санхүүгийн дэмжлэг	19,576.6	18,898.0	678.6	16,589.8	17,469.1	-879.3

Завхан аймгийн ТЭЗ-н төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	Тусгай зориулалтын шилжүүлэг	46,674.0	45,969.0	705.0	45,332.7	46,323.7	-991.0
5	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	423.6	423.6	0.0	515.7	515.7	0.0
6	Орон нутгийн хөгжлийн сан	5,156.3	4,508.3	648.0	5,721.0	5,987.6	-266.6
	ДҮН	79,955.1	77,777.5	2,177.6	77,534.8	79,671.7	2,136.9



Аймгийн ИТХ-ын хуралдааны 2021 оны 17 дугаар тогтоолоор 2021 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг дор дурдсанаар тодотгон баталжээ.

Хүснэгт-4 /сая.төг/

д/д	Төсвийн эх үүсвэр	Сангийн яам /тодотгол/	АИТХ /тодотгол/	Зөрүү
1	Татварын болон татварын бус орлого	9,375.6	9,657.6	-282.0
2	Аймгийн төсөвт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	17,469.1	17,469.1	0.0
3	Аймгийн төсөвт улсын төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг	46,323.7	46,323.7	0.0
4	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	515.7	515.7	0.0
5	ОНХС-д олгох орлогын шилжүүлэг	5,987.6	5,987.6	0.0
6	Төсөвт байгууллагын өөрийн орлогоос		68.2	-68.2
7	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		304.3	-304.3
	ДҮН	79,671.7	80,326.2	-654.5

Сангийн яамны дүнгээс 654.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан нь орон нутгийн суурь зарлагыг сангийн яамны баталсан дүнгээс 506.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсантай холбоотой байна.

Төсвийн орлогын гүйцэтгэлийн талаар:

- ✓ Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээр нийт 69,780.4 сая төгрөгийн санхүүжилт бүрэн олгогдсон байна.

Төсөв хоорондын шилжүүлгийн гүйцэтгэл

д/д	Төсвийн эх үүсвэр	Хүснэгт-5 /сая.төг/		
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
2	Аймгийн төсөвт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	17,469.1	17,469.1	0.0
3	Аймгийн төсөвт улсын төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг	46,323.7	46,323.7	0.0
5	ОНХС-д олгох орлогын шилжүүлэг	5,987.6	5,987.6	0
	ДҮН	69,780.4	69,780.4	0

- ✓ Эрүүл мэндийн даатгалын сангаас 515.7 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 705.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь 190.0 сая төгрөг илүү байна.
- ✓ Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого болон сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлогоос 1,746.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 2,406.2 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Энэ нь хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлөлтийг төлүүлэх талаар хууль хяналтын байгууллагатай хамтран ажилласан нь үр дүнгээ өгсөн байна гэж үзлээ.

ЗОРИЛТ 2. ОРОН НУТГИЙН ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ

Орон нутгийн зардлын төлөвлөлтийг салбар бүрээр авч үзвэл:

1. Орон нутгийн суурь зарлагыг Сангийн яам 27,113.1 сая төгрөгөөр тодотгон баталсан нь анх баталснаас 879.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн бөгөөд энэ нь бараа үйлчилгээний бусад зардал байна.

Аймгийн суурь зарлагын төлөвлөлт

д/д	Зардлын төрөл	Хүснэгт-6 /сая.төг/		
		Сангийн яам /тод/	АИТХ /тод/	Зөрүү
1	Аймгийн ИТХ	271.6	544.2	-272.6
2	Сумын ИТХ	1,402.0	1,366.2	35.8
3	Аймгийн ЗДТГ	2,596.6	3,316.4	-719.8
4	Сумын ЗДТГ	7,885.2	8,022.5	-137.3
5	Хот тохижуулах газар	321.6	600.2	-278.6

Завхан аймгийн ТЕЗ-н төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6	Ойн анги	144.8	134.8	10.0
7	Байгаль орчны газар	962.6	924.5	38.1
8	Аймгийн халамжийн сан	89.3	89.3	0.0
9	Санхүүгийн хяналт аудитын алба	134.6	179.8	-45.2
10	Аймгийн засаг даргын ерөнхий данс	521.2	523.3	-2.1
11	Орон нутгийн өмчийн газар	126.6	170.7	-44.1
12	Хүүхдийн цэцэрлэг /тогтмол зардал	1,551.9	1,327.6	224.3
13	Ерөнхий боловсролын сургууль /тогтмол зардал/	5,454.0	4,759.3	694.7
14	Орон нутгийн хүүхдийн байгууллага /тогтмол зардал	64.3	64.3	0.0
15	газар зохион байгуулалт, геодез, зураг зүйн газар /тогтмол зардал/	29.4	29.4	0.0
16	Эрүүл мэндийн төв /тогтмол зардал/	572.7	673.1	-100.4
17	Орон нутгийн музей	260.9	257.0	3.9
18	Орон нутгийн номын сан	157.5	173.4	-15.9
19	Аймгийн театр	1,126.3	924.0	202.3
20	Сумдын соёлын байгууллагууд	2,411.3	2,430.0	-18.7
21	Биеийн тамир, спортын газар	778.7	820.0	-41.3
22	Авто замын сан	250.0	250.0	0.0
23	Соёлын хэлтэс		40.0	-40.0
	ДҮН	27,113.1	27,620.0	-506.9

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2021 оны 17 дугаар тогтоолоор нийт зарлагыг 27,620.0 сая төгрөгөөр баталсан нь Сангийн яамны баталсан төсвөөс 506.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ. Энэхүү зардлыг өмнөх оны үлдэгдэл болон татварын нэмэлт даалгаврын орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

2. Тусгай зориулалтын шилжүүлгийн зарлагыг Сангийн яам 46,323.7 сая төгрөгөөр тодотгон баталсан нь анх баталснаас 991.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь цалингийн зардал байна. ЕБС болон СӨБ-ийн байгууллагын алба хаагчдын үр дүнгийн урамшууллыг төсөвт тусгаагүй байсныг төсвийн тодотголоор нэмж баталсан байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлагын төлөвлөлт

хүснэгт-7 /сая.төг/

д/д	Зардлын төрөл	Сангийн яам /тод/	АИТХ /тод/	Зөрүү
1	Хүүхдийн цэцэрлэг	11,274.0	11,274.0	0.0
2	Ерөнхий боловсролын сургууль	25,003.8	25,003.8	0.0
3	Эрүүл мэндийн төв	9,188.0	9,703.7	515.7
4	Газар зохион байгуулалт, геодез, зураг зүйн газар	638.0	638.0	0.0
5	Орон нутгийн хүүхдийн байгууллага	219.9	219.9	0.0
	ДҮН	46,323.7	46,839.4	515.7

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2021 оны 17 дугаар тогтоолоор тусгай зориулалтын шилжүүлгийн зарлагын төлөвлөгөөг Сангийн яамны баталсан дүнгээс 515.7 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь эрүүл мэндийн даатгалын санхүүжилт байна.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн зарлагын төлөвлөгөөг Аймгийн ИТХ-ын хуралдааны 2021 оны 17 дугаар тогтоолоор 3,623.8 сая төгрөгөөр, АОНХС-аас сумдад олгох шилжүүлгийг 2,235.4 сая төгрөгөөр баталжээ. Мөн урд оны үлдэгдлээс 2,369.7 сая төгрөгийг санхүүжүүлэхээр сумдын ИТХ-аар баталжээ.
4. Сумдын сум хөгжүүлэх сангийн зарлагын төлөвлөгөө буюу эргэн төлөгдөх зээлд 2,262.7 сая төгрөгийг олгохоор төлөвлөсний 670.2 сая төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс, 1,592.5 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр сумдын ИТХ-аар баталжээ.

Төсвийн зарлагын гүйцэтгэлийн талаар:

Аймгийн ТЭЗ 2021 онд нийт 85,079.5 сая төгрөгийн зардал санхүүжүүлэхээр төлөвлөж 79,923.2 сая төгрөгийн зардалтай ажиллаж, төсвийг 5,156.3 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Энэ нь нийт төсвийн 6.1 хувь бөгөөд Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт хангалтгүй байна гэж үзлээ.

Нийт зардлын гүйцэтгэл

д/д	Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хүснэгт-8 /сая.төг/	
				Хэмнэл/+/ хэтрэлт/-/	Элэх хувь
1	НИЙТ ЗАРДАЛ	85,079.5	79,923.2	5,156.3	100.0
2	УРСГАЛ ЗАРДАЛ	74,278.6	72,021.9	2,256.7	90.1
3	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	46,299.7	45,796.6	503.1	57.3
4	Ажил олгогчоос төлөх НДШ	6,269.8	6,149.3	120.5	7.7
5	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,071.7	8,805.6	266.1	11.0
6	Хангамж бараа материалын зардал	2,150.9	1,990.9	160.0	2.5
7	Норматив зардал	2,681.5	2,217.8	463.7	2.8
8	Эд хогшил урсгал засварын зардал	501.3	434.0	67.3	0.5
9	Томилолт зочны зардал	329.3	280.1	49.2	0.4
10	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,635.7	2,512.5	123.2	3.1
11	Бараа үйлчилгээний бусад зардал	4,338.7	3,835.1	503.6	4.8
	ТАТААС	7.5	0.0	7.5	0.0
12	Хувийн хэвшлийн байгууллагад өгөх татаас	7.5	0.0	7.5	0.0
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,385.1	1,344.4	40.7	1.7

Завхан аймгийн ТЕЗ-н төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

13	Бусад урсгал шилжүүлэг буюу тэтгэмж урамшуулал	1,385.1	1,344.4	40.7	1.7
14	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,408.3	6,556.9	2,851.4	8.2
15	Бусад хөрөнгө	7,145.6	5,233.0	1,912.6	6.5
16	Эргэж төлөгдөх зээл	2,262.7	1,323.9	938.8	1.7

Төсвийн зарлагын гүйцэтгэлийг салбар бүрээр нь авч үзвэл:

✓ **Орон нутгийн зарлагын төсвийн гүйцэтгэл:**

Орон нутгийн төсөвт байгууллагын үйл ажиллагааны 31,314.9 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж 27,406.2 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлж орон нутгийн төсөвт байгууллагуудын зардлыг 3,908.7 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Энэ нь орон нутгийн төсөвт байгууллагууд зардлын ангилал бүрд хэмнэлт бий болгосон, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зарим ажлууд хийгдээгүй, СХС-ийн зээлийг төлөвлөсөн хэмжээнд олгоогүй зэрэгтэй холбоотой байна.

Орон нутгийн төсөвт байгууллагууд нь тайлант оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 1,032.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, ОНХС, СХС-ийн зарцуулаагүй 2,876.3 сая төгрөгийг үлдэгдлээр тайлагнажээ.

Орон нутгийн хөгжлийн сан:

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд 3,623.7 сая төгрөгийн 68 ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн байна. Төрийн аудитын газраас 2021 онд төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх саналын хүрээнд ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийж 1,121.6 сая төгрөгийн 10 арга хэмжээг хасах саналыг хүргүүлсэн байна. Аудитаар үр ашгийг дээшлүүлэх саналын хэрэгжилтийг шалгахад 138.0 сая төгрөгийн 3 ажлыг төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ОНХС-ийн аудитаар ОНХС-ийн журам зөрчсөн, үрэлгэн зарцуулалт гаргасан, өмнөх аудитаар өгөгдсөн зөрчлийг давтан гаргасан, батлагдсан зураг төсөвгүй ажил санхүүжүүлсэн, хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл шаардлага хангаагүй зэрэгтэй холбоотой 513.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж зөвлөмж хүргүүлсэн байна.

Сумдын ОНХС-д Аймгийн ОНХС-аас 2,235.4 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталж, бүрэн олгосон байна. Сумдын ОНХС-ийн аудитаар ажлын гүйцэтгэлийн тайланг ирүүлээгүй байхад санхүүжилт олгосон, хийгдсэн ажлыг комисс хэмжилт хийж хүлээж аваагүй, ажлууд гэрээт хугацаандаа хэрэгжээгүй, ОНХС-ийн журам зөрчин багш сурагчдыг урамшуулсан, ОНХС-ийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг зориулалтыг өөрчлөхдөө иргэдээс санал авч эрэмбэлээгүй, ИТХ-ын тогтоол гаргаагүй, ажил дуусаагүй байхад санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн зэрэг зөрчилтэй холбоотой 254.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж зөвлөмж хүргүүлсэн байна.

Сум хөгжүүлэх сан:

2021 онд СХС-ийн зээлд 2,262.7 сая төгрөгийг олгохоор төлөвлөснөөс 1,323.9 сая төгрөгийг олгосон нь 58.5 хувь байна. Сум хөгжүүлэх зээлийн зээлийн эргэн төлөлт удаашралтай, гэрээний хугацаанд эргэн төлөлтийг бүрэн барагдуулдаггүй, хугацаа

хэтэрсэн зээлийн үлдэгдэл өндөр байгаа зэрэгтэй холбоотой зарим сум тайлант онд сум хөгжүүлэх зээлийг олгоогүй байна.

Сум хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээлийн авлага 2021 оны эцэст 4,846.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд өмнөх оноос 658.7 сая төгрөгөөр буюу 12 хувиар буурсан байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага

Хүснэгт-9 Сая.төг

д/д	Сумын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
1	Алдархаан	221.2	231.2	-10.1	4.8
2	Асгат	177.2	111.8	65.4	2.3
3	Баянтэс	183.3	149.5	33.8	3.1
4	Баянхайрхан	217.5	213.4	4.2	4.4
5	Дөрвөлжин	152.3	204.1	-51.8	4.2
6	Завханмандал	199.3	146.6	52.7	3.0
7	Идэр	181.7	156.6	25.1	3.2
8	Их-Уул	234.7	232.3	2.4	4.8
9	Нөмрөг	164.0	144.3	19.7	3.0
10	Отгон	166.1	130.6	35.5	2.7
11	Сантмаргаз	183.7	165.0	18.8	3.4
12	Сонгино	130.1	114.3	15.8	2.4
13	Тосонцэнгэл	497.8	472.6	25.2	9.8
14	Тэс	193.8	139.1	54.6	2.9
15	Түдэвтэй	180.4	119.4	61.1	2.5
16	Тэлмэн	131.8	114.2	17.6	2.4
17	Улиастай	978.2	836.8	141.4	17.3
18	Ургамал	181.4	144.2	37.2	3.0
19	Цэцэн-Уул	205.3	126.7	78.6	2.6
20	Цагаанхайрхан	166.8	176.1	-9.4	3.6
21	Цагаанчулуут	235.2	227.3	7.9	4.7
22	Шилүүстэй	209.4	152.5	56.9	3.1
23	Эрдэнэхайрхан	130.8	169.5	-38.7	3.5
24	Яруу	183.2	168.6	14.6	3.5
Нийт дүн		5,505.3	4,846.6	-658.7	100

2021 онд “Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулахаар зохион байгуулсан ажлын үр дүн”-д эрсдэлийн аудит хийж, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлд алданги тооцож, хугацаа хэтэрсэн зээлдэгчдийг шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлэн, авлагыг барагдуулах талаар албан шаардлага хүргүүлсэн.

✓ Тусгай зориулалтын шилжүүлгийн зарлагын төсвийн гүйцэтгэл:

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд нь тайлант онд 53,764.7 сая төгрөгийн зардал санхүүжүүлэхээр төлөвлөж 52,517.1 сая төгрөгийн зардалтай ажилласан нь төсвийг 1,247.6 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Энэхүү хэмнэлт нь зардлын ангилал бүрд бий болсон хэдий ч байр ашиглалттай холоотой тогтмол зардал, норматив зардал буюу хоол хүнс зэрэг зардлуудад илүү хэмнэлт бий болсон байна.

Хэмнэгдсэн зардлын 799.7 сая төгрөгийг улсын төсөвт, 447.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

ТЕЗ-ийн төсвийн зарцуулалтыг судлан үзэхэд төсвийн хэмнэлтээс хөрөнгө бэлтгэсэн зөрчил байна. Тухайлбал орон нутгийн төсөвт байгууллагууд 479.7 сая төгрөгийн, Боловсролын байгууллагууд 549.6 сая төгрөгийн, бусад байгууллага 66.0 сая, нийт 1,095.3 сая төгрөгийн хөрөнгийг бэлтгэсэн байна. Үүний 430.2 сая төгрөгийн хөрөнгийг нэмэлт санхүүжилтийн хөрөнгөөр, 665.1 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн үйл ажиллагааны санхүүжилтээс бэлтгэсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны санхүүжилтээс бэлтгэсэн хөрөнгийн бэлтгэх зөвшөөрлийг судлан үзэхэд 108.9 сая төгрөг нь Аймгийн ИТХ-ын шийдвэртэй, СӨБ-ийн төсвөөс багш хөгжлийн танхим ажиллуулахад зориулж ТЕЗ-ийн харьяа 38 хүүхдийн цэцэрлэгт 314.0 сая төгрөгөөр хөрөнгө бэлтгэсэн нь эрх бүхий байгууллагын шийдвэргүй, 242.2 сая төгрөгийн хөрөнгийг төсөвт тусгагдсан бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардлаас санхүүжүүлсэн байна.

Дээрх байдлаас дүгнэхэд сумдын ИТХ нь өмнөх оны үлдэгдлээс хөрөнгө бэлтгэх зөвшөөрөл олгосон байна гэж үзлээ. Энэхүү байдалд дээд шатны төсөв захирагч хяналт тавих талаар ажил хийгээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг хуваарилах гэсэн заалттай нийцэхгүй байна.

ЗОРИЛТ 3. НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО, ЗАРДАЛ

Нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 7,235.6 сая төгрөгийн орлого төвлөрч 6,024.1 сая төгрөгийг урсгал зардалд, 415.8 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулж, 715.3 сая төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлж 818.3 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй байна.

Нэмэлт санхүүжилтийн орлого

д/д	Орлогын төрөл	Хүснэгт-10 /сая.төг/	
		Өмнөх он	Тайлант он
1	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив	21.8	32.3
2	ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28.9	207.3
3	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,292.6	3,759.5
4	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,737.5	3,122.9
	Эрүүл мэндийн даатгалын сан		113.6
	ДҮН	4,080.8	7,235.6

Нэмэлт санхүүжилтийн дансаар боловсролын салбарын хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажиллаж байгаа алба хаагчдын тэтгэмж, эрүүл мэндийн байгууллагад дээд шатны төсөв захирагчаас олгосон цар тахлын үед ажилласан алба хаагчдад олгох мөнгөн урамшуулал зэрэг санхүүжилтүүд дамжсан байна.

ЗОРИЛТ 4. АВЛАГА, ӨГЛӨГ

Авлага:

Авлагын дансны эхний үлдэгдэл 6,601.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 6,811.0 болж, 749.5 сая төгрөгөөр өссөн бөгөөд нийт авлагын 71.1 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага эзэлж байна.

Авлагын үлдэгдэл

Хүснэгт-11 /сая.төг/

Авлагын ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт(-)	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбоотой авлага	59.0	100.0	+41.0	1.5
Төлбөртэй үйлчилгээний авлага	153.9	488.0	+334.1	7.2
Байгууллагаас авах авлага	143.1	384.1	+241.0	5.6
Дансны авлага /ТӨҮГ/	106.1	171.1	+65.0	2.5
Татвар НДШ -ийн авлага /ТӨҮГ/	4.1	1.3	-2.8	0.0
Татаас санхүүжилтийн авлага	-	714.5	+714.5	10.5
Хувь хүнээс авах авлага	5,595.3	4,952.0	-643.3	72.7
Нийт дүн	6,061.5	6,811.0	+749.5	100
Байгууллагын төрлөөр				
Төсвийн байгууллага	5,715.0	6,411.3	+696.3	94.1
Төрийн сан	153.6	153.6	-	2.3
Төсөл сан	41.5	41.5	-	0.6
ОНӨҮГ	151.3	204.5	+53.2	3.0
Нийт дүн	6,061.5	6,811.0	+749.5	100

Нийт авлагын 94.1 хувийг төсвийн байгууллага, 2.3 хувийг төрийн сан, 0.6 хувийг төсөл сан, 3 хувийг ОНӨҮГ-ын авлага тус тус эзэлж байна.

Төсөвт байгууллагын авлага

Төсөвт байгууллагын 6,411.3 сая төгрөгийн авлагын 4,846.6 сая төгрөг буюу 75.6 хувь нь сум хөгжүүлэх сангийн, 74.5 сая төгрөг буюу 1.2 хувь нь сумдын ОНХС-ийн, 201.5 сая төгрөг буюу 3.1 хувь нь орон нутгийн төсөвт байгууллагуудын, 57.8 сая төгрөг буюу 0.9 хувь нь боловсролын салбарын байгууллагуудын, 1,224.3 сая төгрөг буюу 19.1 хувь нь эрүүл мэндийн салбарын байгууллагын, 6.6 сая төгрөгийн 0.1 хувь нь хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын байгууллагын авлага байна.

Төсөвт байгууллагын авлагад Байгаль орчин, аялал жуулчлалын газар өмнөх оны санхүүгийн тайланд урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн 55.6 сая төгрөгийг тайлант онд байгууллагаас авах авлагаар тусгаж тайлагнасан байна. Тус байгууллагын 55.6 сая төгрөгийн авлага нь 2020 онд үүссэн он дамжсан авлага бөгөөд ажил гүйцэтгүүлэхээр 2 байгууллагатай гэрээ байгуулж, урьдчилгаа санхүүжилт олгосон боловч тухайн ажлууд бүрэн хийгдээгүй, хийгдсэн ажлууд шаардлага

хангахгүйн улмаас авлагаар тусгагдсан байна. Энэхүү авлагыг барагдуулах талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Төрийн сангийн авлага

Аймгийн төрийн санд олон жил он дамжсан, 20 гаруй жилийн насжилттай 153.6 сая төгрөгийн эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага байна.

Төсөл сангийн авлага

Төсөл сангийн 41.5 сая төгрөгийн авлага нь Орон нутгийн хөрөнгө оруулалтаар он дамжин хийгдсэн ажлын техник хяналтын зардлыг барьцаа хөрөнгийн данснаас зарцуулсныг аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас барьцаа хөрөнгийн дансанд буцаан төвлөрүүлэх авлага байна.

ОНӨҮГ-ын авлага

ОНӨҮГ-ын авлага өмнөх оноос 53.2 сая төгрөгөөр нэмэгдэж, 204.5 сая төгрөг болсон байна. “Амь-Ус трейд” ХХК-ийн авлага 40.2 сая төгрөгөөр, “Тосон-оочирт хайрхан” ОНӨААТҮГ-ын авлага 17.5 сая төгрөгөөр өссөн нь гол нөлөө үзүүлж байна. Тус авлага нь ОНӨҮГ-уудын үйл ажиллагааны хүрээнд бий болсон байна.

Мөн 2021 онд ковидоор өвчилсөн иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлын хэмнэлт буюу тухайн төсвийн жилд ашиглагдаагүй үлдэгдлийг төсвийн дараагийн жилд үргэлжлүүлэн зарцуулахаар авлага үүсгэсэн 17 сумын Эрүүл мэндийн төвд нийт 566.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

Өглөг:

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 2,144.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 2,288.3 сая төгрөг төгрөг болж, 143.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөрийн үлдэгдэл

Хүснэгт-12 /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн (+) Буурсан (-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	840.1	983.9	+143.8	100
Өглөг	215.9	335.5	+119.6	34.1
Ажилчидтай холбогдсон өглөг	45.5	71.6	+26.1	7.3
Бараа үйлчилгээний зардлын өглөг	162.7	256.3	+93.6	26.0
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	7.7	7.7	-	0.8
Бусад өглөг	624.1	648.3	+24.2	65.9
Байгууллагад төлөх өглөг	134.1	293.3	+159.2	29.8
Хувь хүмүүст төлөх өглөг	12.4	38.2	+25.8	3.9
Татварын өглөг /ТӨҮГ/	143.5	87.3	-56.2	8.9
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	28.7	4.6	-24.1	0.5
Дансны өглөг /ТӨҮГ/	305.2	224.7	-80.5	22.8
Урт хугацаат өр төлбөр дүн	1,304.4	1,304.4	-	100
Урт хугацаат зээл	1,304.4	1304,4	-	
ДҮН	2,144.5	2,288.3	+143.8	100

Богино хугацаат өр төлбөр байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	318.7	625.3	+306.6	63.6
Төрийн сан	41.6	41.6	-	4.2
ОНӨҮГ	479.8	317.0	-162.8	32.2
ДҮН	840.1	983.9	143.8	100

Богино хугацаат өр төлбөр

Богино хугацаат өр төлбөрийн 625.3 сая төгрөгийн буюу 63.6 хувь нь төсөвт байгууллагын, 41.6 сая төгрөг буюу 4.2 хувь нь төрийн сангийн, 317.0 сая төгрөг буюу 32.2 хувь нь орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн өр төлбөр байна.

Урт хугацаат өр төлбөр

Урт хугацаат өр төлбөрийн эхний үлдэгдэл 1,304.4 сая төгрөг бөгөөд тайлант онд нэмэгдээгүй байна. Тус өглөг нь Азийн хөгжийн банкнаас нийтийн ахуй үйлчилгээг дэмжих чиглэлээр “Амь-Ус трейд” ХХК-ийн авсан урт хугацаат зээл бөгөөд 20 гаруй жилийн насжилттай өглөг байна.

Төсөвт байгууллагын өр төлбөр

Хүснэгт-13 /сая.төг

Салбар	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Орон нутаг	186.7	70.8	-115.9	11.3
Боловсрол, шинжлэх ухааны яам	96.4	227.1	+130.7	36.3
Эрүүл мэндийн яам	35.6	327.4	+291.8	52.4
Нийт дүн	318.7	625.3	+306.6	100

Төсөвт байгууллагын өр төлбөр өмнөх оноос 306.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд:

- Боловсролын салбарын байгууллагуудын өр төлбөр 130.7 сая төгрөгөөр өссөн бөгөөд Улиастай сумын 1 дүгээр цэцэрлэгийн түрээсийн өглөг, Баянтэс сумын цэцэрлэг, Улиастай сумын 1 дүгээр сургуулийн түлш халаалтын өглөг гол нөлөө үзүүлж байна.
- Эрүүл мэндийн салбарын байгууллагуудын өр төлбөр 291.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ковид-19 цар тахалтай холбоотой үүссэн өглөг байна.
- Орон нутгийн байгууллагуудын өр төлбөр тайлант онд 115.9 сая төгрөгөөр буурсан байна.

Төрийн сангийн өр төлбөр

Аймгийн төрийн санд олон жил он дамжсан, 20 гаруй жилийн насжилттай 41.6 сая төгрөгийн эзэн холбогдогч нь тодорхойгүй өглөг байна.

ОНӨҮГ-ын өр төлбөр

ОНӨҮГ-ын өр төлбөр өмнөх оноос 162.8 сая төгрөгөөр буурсан байна.

ДҮГНЭЛТ:

- I. Батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргах гэсэн Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.
- II. Төсөвт байгууллагуудын хүрээнд 665.1 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна.
- III. Төрийн аудитын байгууллагаас өгсөн 2021 оны төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх саналын хэрэгжилт хангалтгүй байна.
- IV. Төсөвт байгууллагуудад тавих шат шатны хяналт хангалтгүй байна.

Завхан аймгийн ТЭЗ-н төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит
Шалгагдагч байгууллагаас ирсэн санал: Аудитын тайлантай холбоотой санал
ирүүлээгүй байна.



МОНГОЛ УЛС
ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
81090 Уластай, Завхан аймаг
Утас: 7575-1155, Факс: 7046-2550
И-мэйл: zavkhan.gov.mn@gmail.com

2022. 04. 20 № 1/444
талай _____ -ны № _____ т

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлантай
танилцлаа.

Тайлант оны төсвийг хэрэгжүүлэх нь төсвийн
шууд захирагчтай хамааралтай тул тухайн төсөв
захирагчид нь холбогдох зөвлөмж, шаардлагыг
хүргүүлэх нь зүйтэй.

Хүндэтгэсэн,

ЗАСАГ ДАРГА



Д.ТҮВШИНЖАРГАЛ

008103060193

ЗӨВЛӨМЖ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.ТҮВШИНЖАРГАЛ ТАНАА

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчилд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Төсөвт байгууллагад тавих шат шатны хяналтыг хэрэгжүүлж, төсвийн сахилга батыг сайжруулах
2. Төрийн аудитын байгууллагаас өгсөн төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх саналын хэрэгжилтийг хангаж ажиллах
3. УИХ, Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого, чиглэлийг хэрэгжүүлэн ажиллах
4. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 11 сарын 05-ны дотор ирүүлэх

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА